

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Аймгийн Засаг даргын Тамгын газар”, “Хотын захирагчийн алба”, “Эрх бүжинхэн цэцэрлэг” зэрэг байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт 80-90%-тай үргэлжилж байна.

“Баян-Өндөр сумын ОНХС”, “Бүсийн оношилгоо эмчилгээний төв”, “Сум дундын ойн анги”, “Хот тохижуулах газар”, “Энхжих мандарваа” ӨЭМТөв, “17 дугаар сургууль”, “Байгаль орчны газар”, “Унага цэцэрлэг”, “Нийтлэг үйлчилгээний алба”-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг (урьдчилсан гүйцэтгэлээр) 2025.12.05-ны өдөр аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

Байгууллагын хяналтад хэрэгжиж байгаа УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврыг 2025.12.08-ны өдөр жилийн эцсийн тайланг и-оффис системд бүрэн оруулсан.

Монгол улсын сайдуудтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилийг 2025.12.25-ны өдөр и-оффис системээр аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

2. Сургалт, зөвлөгөөн

- 2025.12.11-ний өдөр Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” цахим сургалт, мэдээллийн цагаар “Төрийн албан хаагчийн чадамжийн хүрээ”, “Чадамжид суурилсан сонгон шалгаруулалт” зэрэг сэдэвт сургалтад байгууллагын Ахлах мэргэжилтэн хамрагдлаа.
- 2025.12.11-ний өдөр аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд “Жендэрийн хариуцлагатай бодлого төлөвлөлт, төсөвлөлт” “Жендэрийн хариуцлагатай ажлын байр” сэдэвт сургалтад ХШҮХМэргэжилтэн П.Даваажаргал хамрагдлаа.



3. Үүрэг даалгавар


- 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр “Баянцагаан соёлын төв”-д зохион байгуулагдсан нэгдсэн өдөрлөгт байгууллагын 1 албан хаагч Баянцагаан, Говил багуудын иргэд, олон нийтэд мэдээлэл түгээж байна.



- 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр “Хэмнэл соёлын төв”-д зохион байгуулагдсан нэгдсэн өдөрлөгт байгууллагын 1 албан хаагч Дэнж, Эрдэнэ, Чингэл багуудын иргэд, олон нийтэд мэдээлэл түгээж байна.



- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2025-12-05 үүрэг даалгаврын хүрээнд:** Аймгийн Засаг даргаар удирдамж батлуулан Эрдэнэт Ус ДТС ОНӨХК, ЭБЦТС ТӨХК, БОЭТ-ийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний чанар, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зэрэг чиглэлийг хамруулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд аудит гүйцэтгэсэн.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР